

**ДУНДГОВЬ АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ 2024 ОНЫ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 10 дүгээр сарын 14

Мандалговь хот

НЭГ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, хүрсэн түвшнийг тусгагдсан зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлж удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Аймаг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалын дагуу хийж үнэлгээний дүнг гаргасан.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төлөвлөгөөний 2024 оны эхний хагас жилийн явцын хэрэгжилтийг нэгтгэн, Засгийн газрын 2020 оны 12 сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ”-ын 6.2.2 заасан аргачлалын дагуу арга хэмжээг үнэлж үзэхэд 197 арга хэмжээний биелэлт 82 хувьтай байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо		197
Үр дүнтэй	100	142
Тодорхой үр дүнд хүрсэн	90	15
	70	16
Эрчимжүүлэх шаардлагатай	50	9
	30	7
Үр дүнгүй	0	8
(хүрсэн түвшин-суурь түвшин)/(суурь түвшин зорилтот түвшин)	100-90	142
	90-70	14
	70-50	17
	50-30	16
	0	8
Хэрэгжилтийн хувь		82

Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төлөвлөгөөний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 29 тэрбум 023 сая төгрөг зарцуулсан байна. Үүнээс: Улсын төсвийн хөрөнгөөр 19982,2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 3931,5 сая төгрөг, хандив тусламж, гадаадын төсөл болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар 5109,4 сая төгрөг зарцуулж хэрэгжүүлсэн байна. Зарцуулсан хөрөнгийг бодлогын хүрээгээр авч үзлээ.

Хөрөнгө санхүүгийн зарцуулалт

№	Бүлэг	Эх үүсвэр	Зарцуулалт / сая төгрөг/	Дүн /сая төгрөг/
1	Хүний хөгжлийн бодлого	УТХО	17892.6	19335.0
		ОНХО	413.6	
		Хандив, тусламж	1028.8	
2	Эдийн засгийн бодлого	УТХО	1684.1	8424.7
		ОНХО	3359.5	
		Төсөл хөтөлбөр	3381.1	
3	Засаглалын бодлого	ОНХО	83.4	83.4
4	Ногоон хөгжлийн бодлого	ОНХО	75.0	173.0
		Хандив, тусламж	98.0	
5	Орон нутгийн тогтвортой хөгжлийн бодлого	УТХО		
		ОНХО		
	Дүн/ сая.төг/	Улсын төсөв: 19,576.7	Орон нутгийн төсөв: 3931.5	Хандив, тусламж: 4,507.9
Нийт дүн				28,016.1

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Аймгийн 5 жилийн үндсэн чиглэлийг 8 бүлгийн хүрээнд 197 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

2024 оны явцын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалын дагуу хийхэд 82 хувьтай байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад нийт 197 арга хэмжээнээс 16 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу үр дүнгүй хэрэгжсэн байна.

2024 оны явцын төлөвлөгөөний хэрэгжилтээс эрчимжүүлэх шаардлагатай 31-69 хувийн хэрэгжилттэй 17, үр дүнгүй буюу 0-30 хувийн хэрэгжилттэй 16 заалт

байна. Цаашид хэлтэс агентлагууд бодит үр дүнг нэмэгдүүлэх тал дээр онцгойлон анхаарч ажиллахаар байна.

Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа төлөвлөлтийн шаардлагад бүрэн нийцүүлээгүй зарим шалгуур үзүүлэлт тодорхойгүй байгаа нь хэрэгжилтийг бодитой үнэлэхэд бэрхшээл тулгарч байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих томоохон арга хэмжээнүүд удаашралтай хэрэгжиж байгаа нь төлөвлөлтөд заагдсан хугацаандаа хийгдээгүй, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй, улсын төсөвт тусгагдаагүй зэрэг хөрөнгө санхүүгээс шалтгаалсан гэж үзэж болохоор байна.

Аймгийн хөгжлийн жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөрөнгө оруулалт, хандив тусламж, төсөл хөтөлбөрийн 29023.1 төгрөгийн санхүүжилтээр бүтээн байгуулалт болон хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн байна.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ / Зөвлөмж /

1. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг бодитой, үнэн зөв тайлагнахад анхаарах.
2. Тайланг хугацаанд нь чанартай гаргах, хэрэгжилтийн үр дүнг тоо баримтаар тодорхой илэрхийлж тайлагнах.
3. Хэрэгжилт удаашралтай болон тасарч болзошгүй заалтуудыг хяналтад авч, эрчимжүүлэх арга хэмжээ зохион байгуулан хэрэгжилт, үр дүнгийн талаар удирдлагуудыг мэдээллээр хангаж ажиллах.

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС